

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр цахимаар хуралдаж “Алдарт эх” одонд тодорхойлох тухай, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар уламжлах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр батлах тухай, Өмчийн тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нартай цахим уулзалтыг зохион байгуулж, аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ажлын албаны мэргэжилтнүүд цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, сумдын хурлын үйл ажиллагааны мэдээллийг сонсож, зөвлөмж өгөв.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн удирдах ажилтны 2021 оны 3 дугаар сарын шуурхай зөвлөгөөн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан зохион байгуулагдаагүй бөгөөд аймгийн Засаг даргаас агентлаг, байгууллагын дарга нарт өгөх үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 13 агентлаг, нийт 15 байгууллагын бүтэц орон тоог баталсан шийдвэр, төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, томилогдсон шийдвэр, хувийн хэрэг, холбогдох бусад баримт бичгийг цахимаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Архангай аймагт коронавируст халдварын нөхцөл байдал 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар Шинээр илэрсэн тохиолдол 15, Улаанбаатар хотоос зөөвөрлөгдсөн – 1, нийт 16 тохиолдол байна.

Үүнд: Эрдэнэбулган – 6, Цэнхэр – 9, Хотонт – 1/зөөвөрлөгдсөн/ тохиолдол тус тус байна.

Архангай аймагт нийт COVID-19-ын батлагдсан тохиолдлын тоо 282 болсон байна. Үүнд:

**2020 онд**

Батцэнгэл – 3 тохиолдол

**2021 онд**

Эрдэнэбулган – 165 тохиолдол

Хайрхан – 30 тохиолдол

Эрдэнэмандал – 56 тохиолдол

Чулуут – 17 тохиолдол

Ихтамир – 1 тохиолдол

Цэнхэр – 9 тохиолдол

Хотонт – 1

Эмнэлэгт хэвтэж байгаа- 37

Эмнэлгээс гарсан нийт -237

Нийт коронавируст халдварын батлагдсан 293 тохиолдол насны хувьд хамгийн бага 10 сартай, хамгийн их 83 нас, дундаж нас 38.2, дундаж ам бүлийн тоо 3.8 байна. Батлагдсан тохиолдлуудын 56% нь эмэгтэй, 44% нь эрэгтэй байна. Гэр бүлийн хавьтал AR 48.5% байгууллага хамт олон AR 12.3% байна.

Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 218 дугаар захирамж гарч, аймгийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэг “Улаан түвшин”-д шилжсэн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цагаас 5 дугаар сарын 08-ны өдрийн 06.00 цаг хүртэл сунгасан.

Аймаг, сумдын төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, айл өрхүүдэд дотоод орчны, мөн байгууллагын гадна талбай, нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, гадаад орчны эцсийн халдваргүйжүүлэлт хийх зорилгоор 4 дүгээр сарын 29-ний өдрийн 06.00 цагаас 5 дугаар сарын 03-ны өдрийн 06.00 цаг хүртэл Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, худалдааны төв, эмийн сан, банк, шатахуун түгээх станц, иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, аймаг сум, хот хооронд зорчих хөдөлгөөнд эмнэлгийн зайлшгүй тусламж, оршуулгын ажилд оролцох, газар тариалан, хүнс, түлээ түлш, өвс, тэжээл, ачаа тээврийн хөдөлгөөнийг тусгай шаардлагаар PCR шинжилгээг үндэслэн Онцгой комиссын шуурхай штабын зөвшөөрлийн бичгээр шалган нэвтрүүлэх постоор нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Аймгийн хэмжээнд хоёр дахь ээлжийн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөж, хоёрдугаар ээлжийн 10000 хүн тун вакцинаас эхний ээлжинд голомтод ажиллаж буй бие бүрэлдэхүүнд хийгдсэн 4000 хүний давтан тунг, үлдсэн 6000 тунг архаг суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, газар тариалан, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, банк, нотариатын ажилчид болон зорилтот бүлгийн иргэдийг нэгдүгээр тунгаар төлөвлөж вакцинжуулах ажлыг эхлээд байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт**

2021 оны 4 дүгээр сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 163.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 163.5 сая төгрөг төвлөрүүлж, аймгийн төсөвт 1035.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 1038.5 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Цахимаар татвар төлөх талаар видео бичлэг, татварын тайлан хүргүүлэх хугацааг сануулсан, татвар хууль тогтоомжтой холбоотой 18 мэдээ, мэдээллийг Архангай аймгийн Татварын хэлтсийн пэйж хуудсанд 2-3 удаагийн давтамжтайгаар байршуулан, 1102 хүн үзэж, 426 хүн шейр хийж, бусдад түгээсэн.

### **Хөрөнгө оруулалт**

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

### **Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа**

Орон нутгийн өмчит 16 төсөвт байгууллагад 60.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 1 төсөвт байгууллагад нэрийн 6.9 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгож иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 4 тогтоол гарсан байна.

## **Санхүүгийн хяналт**

Төвшрүүлэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, төсөвт албан байгууллагууд, сумын Орон нутгийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангийнг хамруулан аудит, хяналт шалгалт хийгдэж, улсын ахлах байцаагчийн 4 төрлийн актаар 1.4 сая төгрөгийн нөхөн төлбөр, 294.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллалаа. Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Цэцэрлэг сумын ЗДТГ-т төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халсантай холбоотой төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн 1 төрлийн актаар 10.6 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоолоо.

“Архангайд үйлдвэрлэв” орон нутгийн өмч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт төлөвлөгөөт аудит, хяналт шалгалтын ажил үргэлжлэн хийгдэж, Цөм сүргийн үржлийн төв, Аялал жуулчлалын мэдээлэл, үйлдвэрлэлийн төвүүдэд аудит, хяналт шалгалт хийгдэж эхэллээ.

## **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт**

2021 оны 4 дүгээр сард аймгийн хэмжээнд гамшиг, аюулт үзэгдэл, ослын нийт 6 удаагийн дуудлага мэдээлэл ирсэнээс объектын гал түймэр 1 удаа, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга 5 удаа тус тус гарч 1 гэр шатаж 5 гэр нурсан байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байршилтай худалдаа олон нийтийн байгууллагуудын барилга байгууламжуудад Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 4 дүгээр сарын 01-нээс 20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Шалгалтанд “Гост-1” супер маркет, “Гост-2” мини маркет, “Гост” худалдааны төв, “Бүрэн-Ар” худалдааны төв, “Нархан” супер маркет, “Цагаан эрчис” бөөний төв, “Дархан нэхий” супер маркет, “Мойлт” худалдааны төв гэсэн нийт 8 объект хамрагдаж, Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, журам, заавар болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 82 зөрчил илрүүлж, 23 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3, мэдэгдэл 3-ийг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мөрдүүлэх, хүн хоорондын зай бариулах, амны хаалт тогтмол зүүлгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт тогтмол хийлгэх, халуун хэмжих, QR код уншуулж бүртгүүлэх талаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний дэлгүүрүүд, худалдааны төвүүд болон төрийн байгууллагуудын нийт 1200 гаруй ажилтан, албан хаагч, иргэдэд заавар, зөвлөмжийг өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт /маск/ зүүхийг уриалж ажиллаж байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 31.246 иргэнд хүрч хандалт авсан байна.

2021 оны 3-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 91 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 34, хулгайлах гэмт хэрэг 24, малын хулгайн гэмт хэрэг 17, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 6, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 27, гэмт хэргийн илрүүлэлт 34.1 хувьтай байна.

Нийт 4373 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 4119 иргэнд 163063.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 166.2 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 47.1 хувьтай байна.

Шүүхийн шинжилгээний алба 4-р сард криминалистикийн шинжилгээ 4, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 19, шүүх эмнэлгийн шинжилгээ 29, тусгай шинжилгээ 11-г хийсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар хүнс, эмийн худалдааны цэгүүдийн халдвар хамгааллын дэглэмийн байдалд 166 объектыг хамруулан 86 зөрчлийг илрүүлж, 88.8 хувийг арилгуулсан байна.

Дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан шар усны үер болох, улс орон нутгийн чанартай авто зам эвдрэх, айл өрх, гудамж талбай усанд автах болзошгүй осол, гэмтэл гаргахаас урьдчилан сэргийлж авто замын арчлалт, засварын ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудад улсын байцаагчийн зөвлөмж, үүрэг өгсөний дагуу тус аж ахуйн нэгжүүд нь А0602 дугаартай, А0603 дугаартай Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн автозамын нийт 70 ширхэг хоолойн орох гарах амсар, 317 км замын зурвас газрын хог, малын сэг зэмийг цэвэрлэж зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Барилгын ажил эхэлж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд барилгын угсралт, барилгын материалын үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл бүхий 15 аж ахуй нэгж байгууллагад барилгын угсралт, үйлдвэрлэлийн чанар, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулахаар улсын байцаагчийн 2 төрлийн 36 заалт бүхий 15 зөвлөмжийг хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтаар 11 үйлчилгээ, 2 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгож, шийдвэрлэсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс иргэн, хуулийн этгээдийн дараах бүртгэлийг хийж гүйцэтгэсэн.

### **Иргэний улсын бүртгэл**

Төрсний бүртгэл – 141

Гэрлэсний бүртгэл - 16

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 5

Эцэг тогтоосны бүртгэл - 2

Үрчилсний бүртгэл - 4

Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 4

Нас барсны бүртгэл - 38

Шинээр иргэний үнэмлэх олгосны бүртгэл - 156

Дахин олгосон – 32

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 224

### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл**

2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс нийт 460 мэдүүлгийг хүлээн авч дараах бүртгэлийн хийж гүйцэтгэлээ.

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 17

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 21

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл - 4

Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 134

Арилжааны гэрээ – 0

Худалдах худалдан авах гэрээ - 29

Бэлэглэлийн гэрээ – 6

Барьцааны эрхийн бүртгэл- 333

Өв залгамжлал – 2

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх - 9

Лавлагаа – 5

Бусад эрхийн бүртгэл - 25

Хууль хяналтын байгууллагад нийт 19 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 8607623 төгрөг, тэмдэгтийн хураамжид 79710 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 7163600 төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

### **Хуулийн этгээдийн улсын бүртгэл**

Шинээр бүртгүүлсэн – 4

Өөрчлөлт – 8

Тамганы хяналтын дугаар олгосон – 4

### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол**

Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан “Боловсролын үнэлгээний шалгуурыг турших нь” онлайн сургалтад Эрдэнэбулган сумын 1, 3-р сургуулийн удирдлага, менежер, багш нар, БСУГ-ын мэргэжилтнүүд, нийт 96 хүн оролцлоо.

Коронавируст халдварын дархлаажуулалтын вакцинд боловсролын салбарын нийт багш, ажилчдын 58.8 хувь буюу 1595 багш, ажилтныг хамруулсан.

Теле хичээл, цахим сургалтын үйл ажиллагаа тасралтгүй зохион байгуулж цэцэрлэгийн 61.4 хувь, ЕБС-ын хүүхдүүдийн 62.5 хувь нь теле хичээлдээ бүрэн хамрагдаж байгаа гэсэн судалгаа байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл явагдаж байгаа бөгөөд бүртгэлийн хугацааг 5 сарын 5 хүртэл сунгасан, нийт бүртгүүлэгчдийн 80 хувь нь хичээл сонголтоо бүрэн хийж, баталгаажуулсан байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтын 7 дугаар сарын 1-нээс 4-ний өдрүүдэд 1, 2-р сургууль дээр зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан нэг ангид 13-15 хүүхэд суулгах, спорт болон бусад залыг ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн.

### **Эрүүл мэнд**

Архангай МСҮТ дээр байгуулсан түргэвчилсэн шинжилгээний цэгт тандалтын зорилгоор болон Эрдэнэбулган сумаас бусад орон нутагруу явж байгаа нийт 2963 хүнээс шинжилгээний сорьц авч, шинжилгээнд хамруулсан.

Вакцинжуулалтын 23 цэгийг байгуулж, коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтад 3927 хүнийг хамруулсан.

Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Чулуут, Хайрхан, Ихтамир суманд батлагдсан коронавируст халдварын тохиолдлуудыг тандан судалж, 1967 ойрын хавьтлыг тогтоож, тусгаарлалтанд аван, 254 тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан.

1442 хүнийг түргэвчилсэн шинжилгээнд, 10226 хүнийг PCR шинжилгээнд хамруулж, коронавируст халдварын 254 тохиолдлыг илрүүлсэн.

Эрдэнэбулган сумын 15 цэцэрлэгийн 1366 хүүхдийн бие өсөлт, хөгжилт, таргалалтын түвшин тогтоох биеийн хэмжилт хийж, үнэлгээ боловсруулалтын шатандаа явж байна.

Эрдэнэбулган сумын бүх цэцэрлэгийн багш ажилчдад ажлын байран дээр идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэндээ дэмжих, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч 200 гаруй багш ажилчид хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлсэн.

Эрүүл мэндийн яамнаас коронавируст халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл (хувийн хамгаалах хэрэгсэл) тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, PSR оношлуур, түргэвчилсэн оношлуурын нөөцийн мэдээллийг [www.burtgel.mohs.mn](http://www.burtgel.mohs.mn) цахим хаягаар 7 хоног тутам программд мэдээллийг оруулж эрүүл мэндийн байгууллагуудаас 7 хоног болгон нөөцийн мэдээллийг программд шивж баталгаажуулан ЭМЯ-ны цахим мэдээллийн хэлтэст илгээж байна.

Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай байгаа хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэх бодисийн нөөцийг нэмэгдүүлэх бэлэн байдлаа ханган ажиллах үүднээс 100 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодисын хангалтыг аймгийн Засаг даргын 2021 оны А/165 дугаар захирамжаар “Мед импорт монгол” ХХК, “Гоо марал дөл” ХХК, “Магос” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан татан авалт хийгдсэн. Аймгийн Засаг даргын 2021 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан хуваарийн дагуу Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Онцгой комисс, Зоонозын өвчин судалын төвд хүлээлгэн өгсөн.

### **Соёл урлаг**

Аймгийн Нийтийн номын сан номын сангийн MonKoha үүлэн технологийн программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд үндсэн фондын 522 нэрийн 2409 ширхэг номыг шивж, бар коджууллаа.

Үндсэн фондын 417 нэр төрлийн 1125 ширхэг номыг хуучин данстай тулгаж, номыг нэг бүрчилсэн бүртгэлд стандартын дагуу шинэчлэн хуулж бүртгэсэн. Үндсэн фондын уншигчдын эрэлт хэрэгцээ хангахгүй болсон урагдаж, гэмтсэн 112 ширхэг номыг сэлбэн засав.

Аймгийн Хөгжимт драмын театр төлөвлөгөөт уран бүтээл болох шинэ уран бүтээлийн “Зүрхнээс уяатай эх орон” тоглолтыг тайзнаа тавьж “Ковид-19” цар тахалын хөл хорионы улмаас орон нутгийн АВ телевизтэй хамтран ажиллаж телевизийн бүтээл болгон үзэгч олондоо хүргэсэн.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2020 оны 4 дүгээр сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1138 иргэн бүртгэлтэй байгаагаас 541 эмэгтэй байна. Шинэ ажлын байр 64 үүнээс байнгын ажлын байр 54, улирлын ажлын байр 9, түр

ажлын байр 1 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 90, зуучлал 79 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 60 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 9, бага- 70, суурь-201, бүрэн дунд- 671, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 19, тусгай мэргэжлийн дунд-21, дипломын бакалаврын-147 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 12 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч ЭМХэлтэс рүү хүргүүлсэн.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж байгаа. 2020 онд “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-д заасан 4 төрлийн үйлчилгээ, Насны хишиг, Эхийн алдар 1 болон 2 дугаар одонтой эхэд олгох мөнгөн тусламж гэсэн 6 төрлийн үйлчилгээ, 2021 оны 1-р улиралд өндөр настны тэтгэвэр, хөгжлийн бэршээлтэй иргэний тэтгэвэр, одой иргэний тэтгэвэр үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн.

2021 оны 4 дүгээр сард нийт 7012 иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө арилжааны банкин дахь өөрийн нэрийн дансаараа дамжуулан авсан байна. Мөн "Ковид-19" цар тахалтай холбоотойгоор 4 дүгээр сарын хүүхдийн мөнгөн тэтгэмжийг энэ сарын 5-нд олгосон ба шинэ төрсөн 119 хүүхэд тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргаад байна.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 5452.8 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 109 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 15.6 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 17.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1787.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ЯХИС-ийн Архангай салбар хамтран Батцэнгэл, Чулуут, Хайрхан, Эрдэнэбулган сумын 4-р багийн хамтарсан багуудад кейс хэлэлцүүлгийг зохион байгуулж, тулгамдаж буй 2 кейсийг хэлэлцэн шийдвэрлэх, кейс менежментийн арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. Мөн Эрдэнэмандал сумын хамтарсан багт цар тахлын үед хамтарсан багаар ажиллах арга зүйн талаар зөвлөгөө мэдээллийг өгч хамтран ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утаснаас ирсэн 7 дуудлага мэдээллийг холбогдох албан хаагчдад шилжүүлж, 5 дуудлага мэдээллийг эцэслэн шийдвэрлүүлсэн, 4 кейсийг сумдын хамтарсан баг, Цагдаагийн газарт шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин арга зүйгээр ханган ажилласан.

Цахим хуудсаар дамжуулан гэр бүлийн харилцаа, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 постер мэдээлэл, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр 50 постер, 4 видео зөвлөмж, мэдээлэл, сэтгэл зүйн 40, нийтдээ 3 чиглэлээр 110 зурагт, 4 видео мэдээлэл нийтэлж, нийтдээ 45000 орчим хүнд хүргэсэн байна.

Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран сумдын 40 эмч, мэргэжилтнүүдэд “Гамшиг онцгой байдлын үеийн сэтгэл зүйн бэлэн байдал” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд 2021 онд 5399.9 мянган толгой мал хаваржиж байна. Үүнээс улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 2 сумын 114 малчин өрхийн 39730 толгой мал, Цэцэрлэг, Хашаат, Өгийнуур, Хотонт, Төвшрүүлэх сумдын 51 малчин өрхийн 24.1 мянган толгой мал Хөвсгөл, Булган, Хэнтий, Төв, Дорнод, Сэлэнгэ аймагт, Баянхонгор, Өвөрхангай, Завхан, Хөвсгөл, Булган аймгийн 20-иод сумаас 176 өрхийн 110 орчим мянган толгой мал, Ихтамир, Өлзийт, Төвшрүүлэх, Жаргалант сумдын 51 өрхийн 19.5 мянган толгой мал бусад сумдын нутагт тус тус отроор хаваржиж байна.

Архангай аймагт 1983.6 мянган толгой эх мал төллөхөөс өнөөдрийн байдлаар 64.7 хувь буюу 1280.6 мянган толгой эх мал төллөж 1236.6 толгой төл мал 97 хувьтай бойжиж байна.

Малын төрлөөр авч үзвэл ингэ 152 толгой буюу 44.2 хувь, гүү 9521 толгой буюу 9.6 хувь, үнээ 37505 толгой буюу 19.1 хувь, эм хонь 822826 толгой буюу 73.2 хувь, эм ямаа 410687 толгой буюу 72.9 хувь нь төллөсөн байна.

Аймгийн нийт мал сүргийн 1 хувь буюу 56871 толгой мал хорогдсон бөгөөд өвчнөөр хорогдсон мал байхгүй байна.

2021 онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой хавар 15.0 мянган га бэлчээрт микро биологийн аргаар, намар 40.0 мянган га бэлчээрт энгийн механик биологийн аргаар, нийт 55.0 мянган га бэлчээрт тэмцэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.

Энэ онд улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 19 суманд 30 гүн өрмийн худгийг шинээр гаргах бөгөөд “Зах зээл ба бэлчээрийн удирдлага” төслийн санхүүжилтээр 10 суманд бэлчээрийн 12 худаг, Хотонт суманд өвс, тэжээлийн агуулах, саравч, Эрдэнэмандал суманд мал төрөөрөх цэг, Эрдэнэбулган суманд хүнсний ногооны зоорь барих, мөн Бизнес инкубатор төвийн тоног төхөөрөмж авах хөрөнгийн асуудлууд шийдвэрлэгдэж зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж холбогдох газарт хүргүүлсэн.

2020 оны эцэст аймгийн хэмжээнд 1489.2 мянган толгой ямаа тоолуулсан бөгөөд 491 тн ноолуур бэлтгэгдэж 60 тэрбум төгрөгийн орлого ноолуур бэлтгэн нийлүүлсэн иргэдийн гар дээр очно. Мөн 2020 онд үндэсний үйлдвэрт тушаасан давхардсан тоогоор 16.0 мянган малчин, мал бүхий иргэдийн ноос, арьс, ширний урамшуулалд нийтдээ 5.0 тэрбум төгрөг орно.

Сумдад ноолуур бэлтгэлийн ажил эхэлсэн бөгөөд 1 кг ноолуурын ханш 120.0-125.0 мянган төгрөг байна.

### **Газар тариалан**

Аймгийн хэмжээнд 15.0 мянган га талбайд үр тариа, үүнээс Улаанбуудайн 10.0 мянган га талбайд, малын тэжээл 3300 га талбайд, хошуу буудай үрийн зориулалтаар 200 га талбайд, тосны ургамал 1500 га талбайд тариална. Төмс 264 га талбайд, хүнсний ногоо 139 га талбайд, жимс жимсгэнэ 69 га талбайд тариалахаар төлөвлөж байна.

Хаврын тариалалтын бэлтгэл ажилд зориулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих санд 2220 тн үр, 133 тн шатахуун, 45 тн бордоо, 37758 литр ургамал хамгааллын бодис, 50 литр үр ариутгагчийн захиалгыг хүргүүлсэн. Үүнээс гадна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Хөдөө аж ахуйг дэмжих” хөтөлбөр, “Нэг малчин-Нэг өвөлжөө-10 ар” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд малчин өрхөд тэжээлийн ургамал тариалахад дэмжлэг болгож энэ онд 700 гаруй га талбайд тэжээлийн ургамал тариалах үр, техник, шатахууны дэмжлэг үзүүлнэ.



Хаврын тариалалтын бэлтгэл ажил 50 гаруй хувьтай явагдаж байгаа бөгөөд тариаланчдыг Улаанбаатар хот, бусад аймгуудаас ирэхэд нь Коронавирусээс урьдчилан сэргийлэх вакцин, PCR-ийн шинжилгээнд хамруулж /356 тариаланч/ улс, аймгийн Онцгой комисс, сумын удирдлагуудтай хамтран халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн тариалалтын ажлаа саадгүй явуулах нөхцөл боломжоор хангаж байна.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

### **Барилга, дэд бүтэц**

2021 оны 4 дүгээр сард улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 13 тэрбум 307.4 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл арга хэмжээний барилгын ажил эхэлсэн.

Мөн 299,2 сая төгрөгийн өртөг бүхий 24 төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг боловсруулж, зураг төсөл боловсруулах тендерийг зарлуулаад байна.

Газрын биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) цахим хаягийг ашиглан Булган, Хангай, Хотонт сумдад газрын дуудлага худалдааг зохион байгуулан 4 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 70289 м<sup>2</sup> газрыг 84.2 сая төгрөгөөр эзэмшүүлэх гэрээг байгуулсан байна. Хангай суманд эзэмшүүлэх нэг дуудлага худалдаанд оролцогчгүйн улмаас хаагдсан байна.

### **Хүнс, үйлдвэр, үйлчилгээ**

2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл 3 тн-оос дээш даацтай машинд захиалга үүсгэн ажиллаж байгаад 4 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн даацын хэмжээ хязгаарлалгүй захиалга үүсгэж байна. 4-р сарын 25-ны байдлаар 860 тээвэрлэлтэд захиалга үүсгэсэн.

2021 оны 4 сарын 23-ны байдлаар хүнсний нөөцийн судалгаа мах 10 тн буюу 1 хоног, гурил 266.3 тн буюу 35 хоног, гоймон 35.5 тн буюу 3 хоног, будаа 65.4 тн буюу 17 хоног, сахар 44.8 тн буюу 18 хоног, ургамлын тос 16.7 тн буюу 9 хоног, давс 24.8 тн буюу 62 хоног, ундны ус 21.1 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 6.3 тн буюу 5 хоног, төмс 41.2 тн буюу 15 хоног, хүнсний ногоо 10 тн буюу 1 хоног, өндөг 0.99 тн буюу 17 хоногийн нөөцтэй байна. Хүнсний нөөцийн мэдээг 7 хоногт 2 удаа авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн ЗДТГ, ОБГ-т хүргүүлж байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эдийн засгаа дэмжих-Эрүүл мэндээ хамгаалах" 10 их наядын төлөвлөгөөний хүрээнд аж ахуйн нэгж, иргэдэд "Ажлын байрыг дэмжих" жилийн 3 хувийн хүүтэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байгаа бөгөөд аймгийн хувьд 2021 оны 3 дугаар сарын 30-ны байдлаар 52 иргэн, 5 аж ахуйн нэгжид 3 тэрбум 256 сая төгрөгийн зээлийг олгоод байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----

